

УВС АЙМАГТ 2020 ОНЫ 3 САРД БОЛСОН ОНЦЛОХ
ҮЙЛ ЯВДЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Үйлчилгээний нэгдсэн төвийн 3 дугаар сарын онцлох ажил

Энэ сарын онцлох ажлаар Нийгмийн даатгалын хэлтсийн Сайн дурын даатгалын үйлчилгээг чухалчиллаа.

2020.01.01-ний өдрөөс эхлэн Нийгмийн даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Сайн дурын даатгал төлөгчдөд таатай үйлчилгээ бий болсон.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420000₮ болсонтой холбогдуулан сайн дурын даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн доод хэмжээ $420000 * 13,5\% = 56700$ төгрөг болсон байна. Бүрдүүлэх бичиг баримт: Иргэний үнэмлэх, Нийгмийн даатгалын дэвтэр (байхгүй бол шинээр нээлгэнэ), Зураг 1% (Нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээлгэх бол)

АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ ЭХ: Хүүхдээ 3 нас хүртэл нь асрах чөлөөтэй байх хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогч нь хариуцан төлнө.

САЙН ДУРЫГ ДААТГУУЛАГЧ ЭХ: Нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эх хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийг 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд, 50 хувийг нь тэтгэмжийн даатгалын сангаас төлнө.

БУСАД ЭХ: Хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд, 50 хувийг нь төрөөс төлнө.

ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ: $420000 * 12,5\% = 26250$ төгрөг

Бүрдүүлэх бичиг баримт: Иргэний үнэмлэх, Нийгмийн даатгалын дэвтэр (байхгүй бол шинээр нээлгэнэ), Зураг 1% (Нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээлгэх бол), Хүүхдийн төрсний гэрчилгээ

Энэ хуулиуд хэрэгжиж эхэлснээр Улаангом суманд Сайн дурын даатгал төлөх эхчүүдийн тоо нэмэгдсэн бөгөөд энэ оны эхний улирал гэхэд 430 иргэн шинээр шимтгэл төлж эхэлсэн ба нийт 2192 иргэн сайн дурын даатгал төлсөн байна.